

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

“Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль”-ийн хэлэлцүүлгийг Нээлттэй Нийгэм Форум нь Монголын залуучуудын эвсэл ТББ-тай хамтран 2018 оны 8-р сарын 15-нд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт оролцогчид залуучуудын хөгжлийн асуудлыг хуулиар зохицуулж, бие даасан агентлаг байгуулж, үндэсний хэмжээнд ажиллах тогтолцоог бүрдүүлж, хуулийг дагаж гарах дүрэм, журмыг боловсруулах, санал авах ажлыг эхлүүлсэн зэргийг сайшаан тэмдэглэхийн зэрэгцээ хуулиар зохицуулсан харилцааг улам боловсронгуй болгох, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр гаргасан зарим санал, шүүмжийг нэгтгэн танилцуулж байна.

Хуулийн төслийн хэлэлцүүлэгт иргэний нийгэм болон залуучуудын байгууллагыг төлөөлөн 30 орчим хүн оролцсон ба уг хэлэлцүүлгийг ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан хөтлөн явууллаа (Оролцогчдын нэрийн жагсаалтыг хавсралтаас үзнэ үү.).

НЭГ. ЕРӨНХИЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

- 1.1 Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль хэрэгжиж эхлээд найман сар өнгөрч байгаа бөгөөд хуулийг дагаж нийт 13 баримт бичиг гарах ёстойгоос ихэнх нь боловсруулалтын шатандаа явна. Үүний зэрэгцээ холбогдох баримт бичгийн төсөл боловсруулах үе шатанд залуучуудын оролцоог хангахад илүүтэй анхаарах шаардлагатай юм. Тухайлбал, Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн дүрмийг Засгийн газар баталсан хэдий ч, боловсруулах үе шатанд оролцоог хангах тал дээр учир дутагдалтай байсанд залуучууд шүүмжлэлтэй хандаж байна. Хуулийг дагаж гарах баримт бичиг батлагдаагүйгээс тухайн зүйл заалтын хэрэгжилтийг холбогдох талаас шаардах боломжийг мөн хязгаарлаж байна. Тухайлбал оюутан, залуучуудад цагаар хөдөлмөр эрхлэх боломжийг нээж өгсөн нь ач холбогдолтой ч журам нь гараагүй тул хэрэгжээгүй байна. Мөн залуучуудын гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа, уламжлал, зан заншлын тухай утга зохиол, уран сайхны бүтээлийг журмын дагуу сонгон шалгаруулж, Залуучуудын хөгжлийг дэмжих сангаас санхүүжүүлэхээр хуулийн 8.5, 8.6 дугаар заалтаар зохицуулсан хэдий ч бүтээл сонгон шалгаруулах журам батлагдаагүй байна. Түүнчлэн, Залуучуудын хөгжлийг дэмжих сангийн тухай нэмэлт нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд ороогүй тул тус сангийн дүрэм батлагдаагүйгээс мөн л энэ заалт хэрэгжих боломжгүй болжээ. Энэ мэт нэлээд олон заалт холбогдох дүрэм, журам гараагүйгээс хэрэгжиж эхлээгүй байна.

Санал: Хариуцсан төрийн байгууллага нь холбогдох дүрэм, журмуудыг залуучууд, иргэний нийгмийн байгууллагын өргөн оролцоотойгоор яаралтай боловсруулж, батлах.

- 1.2 Хуульд баримт бичиг гаргахыг үүрэг болгоогүй боловч тухайлсан хөтөлбөр, төлөвлөгөө батлахгүйгээр хэрэгжилтийг зохион байгуулах боломжгүй заалтууд нэлээд тусжээ. Тухайлбал, 11.1.5, 12.1.1, 12.2 дугаар заалтыг дурдаж болно.
- 1.3 Хуульд төлөвлөсөн ажил бүрт хариуцах төрийн байгууллагыг зааж өгсөн нь чухал ач холбогдолтой болжээ. Гэсэн хэдий ч тухайн яам, агентлаг энэ чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлэх, хэрэгжилтийн тайлан гаргах эсэх асуудлыг нарийвчлан зохицуулаагүй байна. Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чухал ач холбогдолтой институт бол Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний болон салбар зөвлөл билээ. Гэтэл хуулийн хэрэгжилтийн талаар холбогдох яам, агентлагаас тайлан мэдээ авч хэлэлцэх үндэсний болон салбар зөвлөлийн чиг үүрэг хууль болон дүрэмд тодорхой тусаагүй байна. Тиймээс хуульд туссан залуучуудын хөгжлийн чиглэлээр хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх эсэх нь төрийн байгууллагын хувьд сайн дурын шинжтэй болжээ.
- 1.4 Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл байгуулах ажил ил тод бус байна. Салбар зөвлөл байгуулах журмыг залуучууд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулалгүйгээр хэлэлцүүлсэн бөгөөд хүүхдийн зөвлөлийн жишгээр журмаа боловсруулжээ. Хуулийн хэрэгжилтэд онцгой үүрэгтэй үндэсний болон салбар зөвлөлийг хэрхэн байгуулах, бүтэц бүрэлдэхүүнд хэн байх гэх мэт чухал асуудлыг нийтлэгээр зохицуулаагүйгээс орон нутаг бүрт хэрэгжилт харилцан адилгүй байна. Нөгөө талаас, залуучуудын иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангахдаа улс төрөөс ангид байлгахад анхаарах шаардлагатай юм.

Санал: Хуульд Үндэсний болон салбар зөвлөлийн чиг үүрэгт салбар хоорондын зохицуулалтын уялдааг хангах хүрээнд хариуцсан төрийн байгууллагын тайлан мэдээг жил бүр авч, Засгийн газрын хуралдаанд танилцуулах, Үндэсний болон салбар зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг илүү оролцоотойгоор бүрдүүлэх зарчмыг тусгах гэх мэт шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах нь зүйтэй. Мөн Үндэсний болон салбар зөвлөлийн дүрмийг залуучуудын өргөн оролцоотойгоор шинэчлэн батлах.

- 1.5 Хууль нь дангаараа хэрэгжих боломжгүй олон зохицуулалтыг агуулсан хэдий ч холбогдох бусад хуульд орох нэмэлт өөрчлөлтийг тусгаагүй байгаа нь зөрчил үүсгэж байна. Тухайлбал, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд Залуучуудын хөгжлийг дэмжих сангийн үйл ажиллагааг хэрхэн явуулах тухай тусгаагүй байна. Мөн ажлын байранд байх цагийн ажлын тоог тогтоосон ч Хөдөлмөрийн тухай хуульд холбогдох өөрчлөлтийг оруулаагүй. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас үзүүлэх дэмжлэгийг дурдсан ч энэ нь холбогдох хууль, журамдаа тусаагүй байна.

Санал: Хуулийн хэрэгжилтэд залуучуудын оролцоотойгоор дүн шинжилгээ хийх замаар холбогдох хууль тогтоомжид оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг боловсруулж, хууль тогтоогчид өргөн барих.

- 1.6 Хуулийн тодорхой заалтууд тунхаглалын шинжтэй байна. Тухайлбал, хуулийн 11-р зүйлийн 11.1.9-д “хувийн хэвшлийн байгууллага /100 ба түүнээс дээш ажилтантай/ нийт ажилтнуудын 5 хувьтай тэнцэхүйц оюутны цагийн ажлын орон тоо гаргах” гэсэн заалтыг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхой бус, холбогдох бусад хуульд дагаж гарсан өөрчлөлт байхгүй тул хэрэгжих боломжгүй юм. Мөн түүнчлэн 11.1.1, 11.1.7, 11.1.8, 12.1.4, 12.3.2, 12.3.4, 12.3.5, 13.1.2, 15.1.4 дүгээр заалтад тодорхой үйл ажиллагааг дэмжих хэмээн оруулсан ч хэрхэн яаж дэмжих нь тодорхойгүй байна. Нөгөө талаас, эдгээр зүйл заалтыг хэрэгжүүлэхийн тулд холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

Санал: Эдгээр заалтын хэрэгжилт хэр байгаа талаар олон нийтэд мэдээлэх, хуульд заасан үндэслэлээр дэмжлэг авах арга замыг тусгасан гарын авлага, мэдээллийн хуудас бэлтгэж түгээх.

1.7 Залуучуудын хөгжлийн тухай хууль нь 15-34 насны залуучуудыг хамрах хэдий ч 15-25 насны зорилтот бүлгийн залуучуудын хөгжлийн асуудлыг хангалттай зохицуулж чадахгүй байна. Гэтэл энэ насны залуучуудад амьдрах ухаан, хувь хүний хөгжил, гэр бүлийн боловсрол олгох, амьдрал, ажилд бэлтгэх чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага тулгамдаж байна. Тухайлбал, төрийн болон төрийн бус байгууллагын асрамжийн газрууд нь хараа хяналтгүй, үл хайхрагдсан, асран хамгаалагчгүй, өнчин, бие махбодь, сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийг 18 нас хүртэл халамжлаад орхиж байгаа нь учир дутагдалтай юм. Түүнчлэн гэмт хэрэгт холбогдсон болон хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхэд залуучуудад чиглэсэн хөтөлбөр үгүйлэгдэж байна.

Санал: Асрамж, халамжийн газар нь хүүхэд, залуучуудыг 18 нас хүрмэгц асрамжаас гаргах биш амьдралаа бие даан авч явах чадвартай болох хүртэл эдийн засаг, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх талаар зохицуулалт бий болгох;

Гэмт хэрэгт холбогдсон хүүхэд залуучуудыг сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад суралцах хугацаанд болон суллагдсаны дараа нийгэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх;

Хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхэд залуучуудыг бие даасан идэвхтэй иргэн болоход бэлтгэх хөтөлбөрийг боловсролын байгууллагаар хязгаарлахгүйгээр Залуучуудын хөгжлийн төвүүдээр дамжуулан, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.

1.8 Хуульд туссан “эх оронч үзэл”, “өв уламжлал”, “ёс заншил” хэмээх нэр томьёо нь хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг өдөөгч болох эрсдэл дагуулдаг тул хуульд туссан нэр томьёог нийтлэг, хүний эрхийн зарчимд нийцсэн байдлаар томьёолох шаардлагатай байна. Уламжлал, зан заншлаас үүдэн хэн ч гадуурхагдаж, доромжлол амсах ёсгүй билээ. Нөгөө талаас, Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүний эрхэд ээлгүй уламжлал, зан заншлыг халах тухай үүрэг хүлээсэн байдаг.

Санал: Эдгээр нэр томьёог хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйд тулгуурлан томьёолох, мөн хэрхэн ойлгох талаар тайлбар, гарын авлага боловсруулах.

1.9 Хуульд туссан зарим нэр томьёо ижил төстэй ойлгогдож байна. Тухайлбал, сайн дурын ажлыг тодорхойлохдоо нийтэд тустай ажлыг хэлнэ хэмээн хуулийн 4.1.6-д заасан боловч, 13.1.2-т нийтэд тустай ажлыг дэмжихээр бие даасан байдлаар оруулсан нь зөрчил үүсгэж байна. Мөн хуулийн 15.2-т сайн дурын ажилд “нийтэд тустай сайн дурын ажил”, “гамшгаас хамгаалах үйл ажиллагаа” аль аль нь орохоор заажээ.

1.10 Хуулийн 15.2-ын дагуу гарах журмаар холбогдох харилцааг зохицуулахдаа сайн дурын ажлыг хэрхэн, хэн тооцох тухай асуудлыг нарийвчлан зохицуулах нь зүйтэй. Энэ үйл явцад залуучуудыг өргөнөөр татан оролцуулах шаардлагатай юм.

1.11 Хуулийн зарим зохицуулалтыг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхой биш байна. Тухайлбал, залуучуудын оролцоог дэмжих бүлэгт “оролцоог дэмжих, оролцох боломжийг бүрдүүлэх, ... зохион байгуулах” гэсэн ч энэ хүрээнд “юу хийх ёстой” болох нь тодорхой биш байна. Үүний улмаас залуучуудын байгууллага, агентлаг нь олон нийтийг хамруулсан аян зохион байгуулах төдийгөөр үйл ажиллагаа нь хязгаарлагдаж байна.

1.12 Хуулийн 14-р зүйлд “Залуучууд шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөл үзүүлэх” тухай зохицуулсан нь тун ач холбогдолтой хэдий ч хэрхэн хэрэгжүүлэх механизм байхгүй байгаа нь учир дутагдалтай юм. Тус зүйлд “...хяналт тавих үйл ажиллагаанд шууд ... оролцох боломжийг бүрдүүлэх”, мөн хуулийн зарчим буюу 5.1.2-т “...шийдвэр боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд залуучуудын иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн оролцоог

хангах” хэмээн тус тус заасан хэдий ч залуучуудын хөгжлийн асуудлыг хариуцаж байгаа яам, агентлагийн үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллага хяналт тавих боломж хязгаарлагдмал байна. Оролцооны чухал хэсэг бол мэдээллийн ил тод байдал билээ. Гэвч төсвийн төслийн хэлэлцүүлэг, төсвийн зарцуулалтын тайлан тавих ажил хийгдсэн эсэх нь тодорхой бус байна.

1.13 Хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т залуучуудад нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх Залуучуудын хөгжлийн төв орон нутагт байна хэмээн зохицуулсан ч сум, дүүргийн түвшинд байгуулах үүрэгтэй эсэх нь тодорхойгүй байна. Тиймээс залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаа жигд бус байна. Тухайлбал, энэ оны 5-р сарын байдлаар Баянзүрх дүүргийн залуучууд хөгжлийн төв өөрийн гэсэн байргүй, үйл ажиллагаагаа эхэлж чадаагүй байна.

Санал: Тиймээс тус төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө батлан ажиллах.

1.14 Тус хуулийн зарим зохицуулалт бусад хуультай зөрчилдөж байна. Тухайлбал, хуулийн 8.1.5, 8.1.6, 10.1.6 дахь заалт нь хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл нэвтрүүлгийн бодлогод цензур тогтоох агуулгатай байна. Гэтэл Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар үүнийг хориглосон байдаг.

1.15 Мөн хуулийн 4-р бүлэгт бүх шатны ИТХ-ын чиг үүргийг заалгүй орхигдуулсан. ИТХ нь залуучуудтай холбоотой хөтөлбөр, төсөв, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, хяналт тавих тун чухал субъект юм. Нөгөө талаас, энэ нь залуучуудын орон нутгийн шийдвэр гаргах түвшинд оролцох боломжийг ч хязгаарлаж байна.

ХОЁР. ТУСГАЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

№	Зүйл, хэсэг	Санал	Тайлбар үндэслэл
1.	4-р зүйл	“Залуу гэр бүл” гэсэн тодорхойлолт нэмэх	Залуу гэр бүлийн тодорхойлолт байхгүйн улмаас насны хувьд залуу юу, эсвэл гэрлээд удаагүй байгаа гэр бүлийг залуу гэр бүл гэсэн бүлэгт хамааруулах уу? гэдэг талаар зохицуулалт байхгүй байна. Залуу гэр бүл гэсэн нэр томъёог оруулж ирснээр зорилтот бүлэгт хуулийн дагуу авч болох дэмжлэгийг илүү бодитой болгоно. Тухайлбал, “Залуу гэр бүл гэж 18-34 насны” эсхүл “гэр бүл болсноос хойш 1-5 жил” гэх жишээний тодорхой заалтыг оруулах.
2.	5.1.2	“залуучуудын олон талт төлөөллийг оролцуулах” гэсэн санааг нэмэх	ХБИ, ЛГБТИК, үндэстний цөөнх гэх мэт бүлгийн оролцоог хангах шаардлагатай. Ингэснээр ард үлдэж байдаг бүлгүүдэд илүү боломж нээгдэх, тэдний эрхийг хуулиар баталгаажуулж буй юм. Хуульд тусгайлан тусгаагүйгээс тэдний оролцоогүйгээр тэдэнд чиглэсэн шийдвэр гаргаж эрх ашгийг нь хохироох тал гардаг.
3.	5.1.3	“залуучуудын үнэлэмж” гэснийг яаж үнэлэх талаар тодорхой болгох	“залуучуудын үнэлэмж” гэсэн үг нь ойлгомжгүй байгаа тул үүнийг нэр томъёоны хэсэгт тайлбарлаж болно.
4.	6.1.1	“эх оронч үзлийг эрхэмлэх” эргэлзээтэй томъёолол	Эх оронч үзэл нь “үндсэрхэг үзэл” гэсэн утга агуулгаар ойлгогдож болохоор байгаа тул анхаарах нь зүйтэй.
5.	6.1.3	“манлайлан” гэснийг “идэвхтэй” гэсэн үгээр солих	Манлайлах гэдэг үгийг босоо, хэвтээ манлайлал гэсэн утгаар ойлгодоггүй. Ихэвчлэн бие хүний манлайлал байдлаар ойлгогддог тул идэвхтэй гэх нь илүү оновчтой тодорхойлолт болно. Нөгөө талаас, манлайлж буй гэсэн нэрийн доор нэг хүн илүү олон боломж эдлэх тохиолдол гардаг.

6.	6.1.5	“сахилга баттай” гэснийг хасах	Хэрхэн тодорхойлох нь ойлгомжгүйн зэрэгцээ, буруугаар ойлгогдох эрсдэлтэй.
7.		6.1.7 “Нийгмийн харилцаанд орж байхдаа нэг нэгнээ гутаан доромжлох” гэж нэмэх	Зөвхөн цахим орчин гэлтгүй бүхий л харилцаанд энэ нь чухал юм.
8.	8-р зүйл		Хувь хүний хөгжлийг дэмжих асуудлыг заавал сургууль хэмээн хязгаарлахгүйгээр өөр хувилбарыг мөн авч үзэх нь зүйтэй. Ялангуяа тусгай хэрэгцээтэй залуучуудын хөгжилд олон хувилбарт боломж нь чухал юм.
9.	8.1.1	“амьдрах ухаан” хичээлийг ерөнхий боловсролын сургуульд заавал, их дээд сургуульд сонгон хэлбэрээр тусгайлан бэлтгэгдсэн багш заахаар найруулгад өөрчлөлт оруулах	Тусгайлан мэргэшсэн багш орохоор заахгүй бол агуулга алдагдах, хуулийн зорилт биелэхгүй болох эрсдэл дагуулдаг.
10.	8.1.4	“уламжлал” гэснийг оновчтой тодорхойлох	Зарим уламжлал нь ялгаварлан гадуурхах, хүчирхийллийн шинжийг агуулсан байдаг бөгөөд хүний эрхэд ээлгүй уламжлалаас татгалзах үүрэгтэй. Тиймээс үүнийг тодотгож оруулах шаардлагатай.
11.	9-р зүйл	“Спорт”-д үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх	Залуучууд спортоор дамжин хөгжих боломжтой.
12.	8.1.5, 8.1.6, 10.1.6	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуультай зөрчилдөж байна.	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт тогтоохгүй” гэсэн заалттай зөрчилдөж байна.
13.	11-р зүйл	“Их дээд сургууль төгсөж, ажил дээр гарч буй залуучуудад ажилд ороход нь дэмжлэг үзүүлэх, ажилд зуучлах” гэсэн заалт нэмэх	Дөнгөж сургуулиа төгсөж буй залуучууд ажлын туршлага зэргээс шалтгаалан ажилд орох боломж хязгаарлагдмал байна.
14.	11.1.2, 11.1.3	Энэ заалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар удирдамж, гарын авлага гарган олон нийтэд түгээх	Залуучуудад энэ төрлийн дэмжлэг маш хэрэгтэй байгаа ч хэрхэн дэмжлэг авахаа мэдэхгүйгээс боломжийг алдаж байна.
15.	11.1.4	“малчин” залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг хэрхэн дэмжих нь тодорхойгүй.	Мал маллах арга ухаанд сургах уу, эсхүл өөр ажил мэргэжил эзэмшүүлэх юм уу?
16.	12-р зүйл	“залуучуудыг тэр дундаа залуу эмэгтэйчүүд, ХБ залуучууд, ЛГБТИК залуучуудыг хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх” тухай заалт нэмэх	Эдгээр бүлгүүд нь хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр. Биеэ хамгаалах чадвар муу, эсхүл өөрийн статусаас хамааран нуугдмал байдаг.
17.	12.1.1	“амины орон сууц” гэсэн санааг нэмэх	Заавал орон сууцанд орох бус амины орон сууц барих, нөхцөлөө дээрдүүлэх боломжтой байхыг дэмжих нь зүйтэй.
18.	13.1.1	“залуучууд өөрсдийн эрх ашигт нөлөөлөх аливаа асуудлаар” гэснийг хасах	Энэ нь залуучуудын асуудлаар биш гэсэн үндэслэлээр төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл явцад залуучуудын оролцоог хязгаарласан шинж агуулсан.
19.	13.1.3	“хүмүүнлэгийн”, “сайн дурын” гэдэг ялгаа нь ойлгомжгүй	Нэр томьёо хэсэгт тодруулж оруулах, шаардлагатай бол энэ чиглэлээр гарын авлага, танилцуулга бэлтгэж, түгээх
20.	13.1.2	“нийтэд тустай” гэж ямар үйл ажиллагааг авч үзэх нь тодорхойгүй.	Залуучуудын иргэний нийгмийн байгууллагын ямар чиглэлээр явуулж буй үйл ажиллагааг хамруулах нь тодорхойгүй байна.
21.	14.1.2	Залуучуудын бүх төлөөллийг хамруулах тухай нэмэлт оруулах, тухайлбал, ЛГБТИК, ХБИ г.м	
22.	19.1.4	“ажлын туршлагад тооцох” гэдэг нь суралцаж буй сэдвээс өөр чиглэлээр оролцсон сайн дурын ажилд хамаарахгүй тул үүнийг тодорхой томьёолох	Залуучууд суралцаж буй сэдвийн бус салбарт сайн дурын ажил хийснийг хэрхэн тооцох нь орхигдсон байна.

23.	19.1.5	“залуучууд” гэж ерөнхий байдлаар оруулах	Учир нь оюутан, суралцагч биш залуучууд цагийн ажил хийх боломжгүй байна.
24.	22.2	Зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүний талаар шинэ зохицуулалт нэмэх	Намын харьяаллаар Зөвлөлд гишүүн оролцуулж байгаа гажуудал байна. Ер нь Засаг даргын үзэмжээр шийдэгдэж байгаа бөгөөд орон нутаг бүр харилцан өөр байна.
25.	22.4.2	“иргэний нийгэм” гэж нэмэх	Ганц залуучуудын биш бусад иргэний нийгмийн байгууллага ч энэ чиглэлээр ажилладаг тул оруулах шаардлагатай. Ялангуяа хүүхдийн байгууллага залуучуудын асуудлаар ажилладаг.
26.	5-р бүлэг	Том хэмжээний төсөл зарлах боломжийг хуульд тусгах	
27.	23-р зүйл	Засгийн газрын тусгай сангийн хуульд холбогдох нэмэлт оруулах	Сангийн тухай хуульд өөрчлөлт орж байж хэрэгжих боломж бүрдэнэ. Тиймээс дүрмийг боловсруулах боломжгүй болж гацаанд орсон.

ХАВСРАЛТ

“Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль”-ийн хэлэлцүүлэгт оролцогчдын нэрс

1. С.Алтанцэцэг Чингэлтэй дүүргийн ГБХЗХ хэлтэс
2. Г.Амарбаясгалан Бодлогод залуусын хяналт ТББ
3. Б.Батчимэг Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд ТББ
4. Б.Болор-Эрдэнэ Монголын Залуучуудын Эвсэл ТББ
5. Г.Буяннэмэх Бодлогод залуусын хяналт ТББ
6. И.Бямбасүрэн Ананд Адвокатс ХХН
7. А.Даваа Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг
8. С.Давааням Монголын Залуучуудын Эвсэл ТББ
9. Т.Есүхэй Монголын Залуучуудын Эвсэл ТББ
10. Н.Мандуул Нийслэлийн Залуучуудын Хөгжлийн газар
11. Ц.Мандхайхатан Бодлогод залуусын хяналт ТББ
12. М.Мишээлт Noble Club
13. А.Отгончимэг Кристина Нобелийн Хүүхдийн сан
14. Б.Очиржанцан “Монгол Өрх” Сэтгэл зүйн хүрээлэн
15. Г.Өлзийжаргал Монголын улаан загалмай нийгэмлэг
16. Б.Солонго Баянгол дүүргийн 1-р хорооны иргэн
17. Г.Төмөрмөнх Ногоон соёл иргэншил хөгжил сан ТББ
18. Н.Тэмүүлэн Түгээмэл хөгжил ТББ
19. Ж.Тэргэл Y-PEER Үндэсний сүлжээ
20. Б.Пүрэвсүрэн Youth Lead олон улсын сүлжээ
21. Б.Төмөр-Очир Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс
22. З.Урантогос Баянгол дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс
23. Т.Уянга Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
24. З.Хишигбаяр Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ
25. Б.Хулан АГБТ Төв ТББ
26. Г.Чинзориг Түгээмэл хөгжил төв ТББ
27. Б.Энхжаргал Иргэний Боловсролын Төв ТББ

Дугаарыг эрхэлсэн: Б.ХИШИГСАЙХАН
ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер

Хаяг: Жамьян гүний гудамж - 5/1 Утас: 976-11-313207
Сүхбаатар дүүрэг, Факс: 976-11-324857
Улаанбаатар - 14240 Вэб: www.forum.mn
Монгол Улс И-мэйл: osf@forum.mn



МОНГОЛЫН ЗАЛУУЧУУДЫН ЭВСЭЛ ТББ